

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

ТА АЯЛАЛД ГАРАХ ГЭЖ БАЙНА УУ, ТЭГВЭЛ...

II нүүрт

ОНЦЛОХ УЛС ТӨР

Б.ЧОЙЖИЛСҮРЭН ҮНДСЭН ХУУЛЬ ЗӨРЧСӨН ҮҮ

II нүүрт

Улаанбаатар: ӨНӨӨДӨР



Өдөр +31
Шөнө +12

ҮЗЭЛ БОДОЛ

ГАЗРЫН НАЙМААЧДАД ТӨР ТӨМӨР НҮҮРЭЭ ХАРУУЛЖ ЭХЭЛЛЭЭ

Дугаарын **60** мөр

Хайран 30 тэрбум төгрөг


Ч.ЧУЛУУН

Эдийн засаг хямарч, наашаа харсан бүхнээс эзэл тусламж гуйн бадар барьж байгаа энэ цаг үед Монгол Улсын ээлжит сонгуулийг бага зардлаар зохион байгуулж яагаад болохгүй гэж. Хэдхэн сарын өмнө Сангийн сайд данс нь улайсан улс орон хүлээж авлаа, Монгол Улсын гадаад өр 2016 оны есдүгээр сарын байдлаар 21 тэрбум ам.доллар, 2017 оны гуравдугаар сараас Хөгжлийн банкны 600 сая ам. долларын өрийг төлж эхэлнэ хэмээн мэдэгдэл хийж ард түмнийхээ үнхэлцгийг хагалах шахаж байсан биш билүү. Гэтэл одоо тэрбум, тэрбум төгрөгөөр сонгууль хийжээр болчихсон давхилдаж явах юм.

Төгсгөл нь III нүүрт



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН



Б.ТУЛГА

Монгол төрийн бодлого шийдвэрийг үл тоодог, хууль зөрчин газар эзэмшдэг, эзэмшсэн газраа зориулалтын дагуу ашигладаггүй даварсан баячуудын үнэн төрхийг илчилсэн хоёр ч үйл явдал өчигдөр БОАЖЯ-нд болов.

Үргэлжлэл нь III нүүрт



Forbes MONGOLIA
MONGOLIAN PROPERTY AWARDS

ЗАЛУУСЫН ХОТХОН

X Apartment

ШИЛДГЭЭР ТОДОРЛОО



Дэлхийн 15 оронд хэвлэгдэн гардаг, санхүүгийн №1 Forbes сэтгүүлээс жил бүр шалгаруулдаг "MONGOLIAN PROPERTY AWARDS"-ын 2016 оны Үл хөдлөхийн шилдэгээр Залуусын хотхон "X Apartment" тодорч "Шилдэг орон сууц" өргөмжлөлийг хүртэн, дэлхийн орон бүрт тодруулдаг энэхүү нэр хүндтэй шагналын эзэн боллоо.

Залуусын хотхон "X APARTMENT" нь хотын төвөөс 4км зайд, нийслэлийн А зэрэглэлийн бүсэд байрлалтай бөгөөд Япон архитекторын орон зайн төгс шийдлээр, өрөө бүрт нарны гэрэл бүрэн тусахаар маш нарийн тооцсон зохион байгуулалтын өвөрмөц төлөвлөлт, 24 цагийн хүлээн авах ресепшн, Монтессори сургалттай цэцэрлэг, таны хэрэгцээг бүрэн хангах бүх төрлийн үйлчилгээг нэг дор бүрдүүлсэнээрээ бусдаас онцлог давуу талтай юм.



Стандарт загвар: 1 өрөө
30 - 32 мкв



Стандарт загвар: 2 өрөө
54 - 64 мкв



Стандарт загвар: 3 өрөө
59.5 - 82 мкв



Дуплекс загвар: 2-4 өрөө
37.5 - 104 мкв

ДЭЛХИЙД ЧАНАРААР ТЭРГҮҮЛЭГЧ ЯПОН БРЭНДҮҮДЭЭР "X APARTMENT"-ЫГ ТОНОГЛОЛОО

Захиалга авах хаяг: Сүхбаатар дүүрэг Улсын драмын театрын хойд талд "УЛААНБААТАР ПРОПЕРТИЗ" ХХК

77009919, 96066329, 88002312, 88030203
www.xapartment.mn

ХААН банк			Хугалгаа хөгжлийн банк		
	Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2408.00	2422.00	ФУНТ	3084.00	3178.00
ЕВРО	2665.00	2733.00	РУБЛЬ	41.80	43.90
ИЕН	21.45	21.76	ЮАНЬ	348.50	351.90

УЛС ТӨР

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

Г.ГАНЧИМЭГ

Өчигдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд замтээврийн салбарын нээлттэй хаалганы өдөрлөг боллоо. Аль ч улсын хувьд аялал жуулчлалын салбарын “цохилох зүрх” нь төмөр зам гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Манай улсын хувьд Улаанбаатар төмөр замын “Аялал жуулчлалын товчоо” энэ чиглэлээр дорвитой ажлуудыг хийж буй нь төв талбайн баруун хэсэгт зассан асарт зочлоход илхэн байсан юм. Тэнд зочилж авсан иргэдээс лавтай олон нь аяны



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

хоног аялалаар явдаг. Дахиад гурав хоног сайхан амраад хоёр хоног явна. Иймэрхүү байдлаар аялал сар орчим үргэжилдэг. Ахмадын эмч, сувилалч энэ аялалыг дагаж явах юм. Энэ аялалаа тун удахгүй эхлэхээр төлөвлөдөг байгаа. Тус бүртээ онцлогтой 12 төрлийн аялалыг бид санал болгож байна.

“Та ихэвчлэн гадаад аялалаа танилцууллаа. Харин дотоодод ямар үйлчилгээ байна вэ?”

“Монголчуудын дотооддоо хийдэг аялалын маршрут тодорхой шүү дээ. Хангайн бүс, говийн бүс, говь-хангайн

ТА АЯЛАЛД ГАРАХ ГЭЖ БАЙНА УУ, ТЭГВЭЛ...

жолоо өргөхөөр шийдсэн биз. Төв талбайг зорьж амжаагүй ч энэ зун хаа нэг тийшээ аялалд гарахаар бэлдэж буй уншигчиддаа мэдээлэл хүргэх үүднээс “Аялал жуулчлалын товчоо”-ны асрыг манай сурвалжлагч хэсэг зорин очсон юм. Улаанбаатар төмөр замын “Аялал жуулчлалын товчоо” нь БНХАУ-ын Өвөр Монголын Хөх хотын аялал жуулчлалын товчоо болоод Хятадын аялал жуулчлалын компаниудтай хамтын ажиллагааны гэрээ хийсэн аж. Ингэснээр хамгийн хямд, найдвартай аялалын хөтөлбөрүүдийг танд санал болгож байгаа юм билээ. Таны аялал дурсамж дүүрэн, зугаатай байхаас гадна амь нас, аюулгүй байдлаа хамгаалуулах нь хамгийн чухал. Түүнчлэн, Хятадын орон нутгийн нислэг, галт тэрэг, үйлчилгээний хамгийн хямд үнийг санал болгосон 12 чиглэлийн аялалын хөтөлбөр хэтэвчинд хэмнэлтэй аж. Олон улсын галт тэрэгний билет захиалгад

аялал жуулчлалын компаниуд асуудал үүсгэдэг нь худлаа биш. Тухайлбал, цагийг нь тулгасан учраас билет олдохгүй тэвдэх тохиолдол ч бий. Харин тус товчоогоор үйлчлүүлж байгаа хүмүүст ийм асуудал үүсэхгүй нь. Тэд 14 хоног болон сарын өмнөөс билетээ урьдчилан захиалдаг аж. Мөн аялалын автобусны түрээсийн үйлчилгээтэй юм байна. Автобус нь 45 хүний суудалтай, жуулчны үйлчилгээнд явах зориулалттайг уншигч авхай танд дуулгая.

Б.Хажидмаа: 12 чиглэлд хийх аялал тус бүртээ онцлогтой

Харин Улаанбаатар төмөр замын Аялал жуулчлалын товчооны захирал Б.Хажидмаагаас дараас зүйлийг тодрууллаа.

“Ний нуугүй хэлэхэд, манай иргэд хэтэвчинд хэмнэлтэй буюу хөнгөлөлт урамшуулалттай хөтөлбөрийг л илүү

сонирхоно. Танай товчоо дотоодын жуулчдын энэхүү хэрэгцээ, сонирхолыг аялалын хөтөлбөрүүддээ хэрхэн тусгасан бол?”

“Гурван төрлийн хөнгөлөлт урамшуулалттай багц гаргасан. Нэгдүгээрт, хамт олны багцыг нэрлэж болно. Энэхүү багцаар 30-аас дээш ажилтантай байгууллага манай компаниар үйлчлүүлж байгаа тохиолдолд дөрвөн хүнийг үнэ төлбөргүйгээр тухайн аялалд явуулах юм. Дараагийнх нь “10+1” хөтөлбөр. Энэ нь ямар учиртай вэ гэвэл нэг аялалын багц 10, 20, 30, 40 хүнтэй явж байж болно. Тэднээс 10 хүнээс нэгийг нь азтанаар шалгаруулж, тухайн аялалын төлбөрийг буцааж өгнө. Гуравдугаарт, найзуудын багц гэж байгаа. Энэ багцад дөрөв, тав, зургуулаа гэх мэтээр цөөхүүлээ явж байгаа тохиолдолд дөрвөн хүн тутмаас нэгийг нь төлбөрийг 30 хувиар хөнгөлөх болно.

“Найз нөхөд, хамт олноороо аяллахаас гадна сүүлийн үед гэр бүлээрээ буюу хүүхдүүд, хөгшдөө дагуулж их аялладаг болжээ.



Аялалын явцад амархан ядарч, уйдаж залхана гээд урьдчилан төсөөлөөгүй нөхцөл байдал үүсдэг шүү дээ?”

“Хүүхдүүд авч явах тохиолдолд хүүхэд харах тусгай үйлчилгээг санал болгодог. Гэхдээ аялалын

бүсийн аялалыг ихэвчлэн хийдэг. Харин Хэнтийн чиглэлд манай дотоодын аялагчид нэг их явдаггүй. Тиймээс жуулчдын хамгийн их явдаг дээрх гурван чиглэлд бид жуулчны баазуудтайгаа гэрээгээ хийчихсэн байгаа. Манайхаар үйлчлүүлж буй хүмүүсийн хувьд энэ нь ямар ашигтай юм гэвэл цаг нь тулгаж очоод 60 мянган төгрөгөөр авдаг үйлчилгээг 90 мянгаар авах зэрэг эрсдэл үүсэхгүй. Хоёрдугаарт, 40 хүнтэй байгууллага хамт олноороо аялахад тээврийн зардал нь маш хямдхан болдог. Өөрөөр хэлбэл, 40 хүн нэг

2017 оны аялалын хөтөлбөр

	Аялалын чиглэл	Аялалын хугацаа	Үнэ	Үнэд багтсан зүйлс	Урамшуулал
1	Эрэн-Халуун рашаан	5 өдөр 4 шөнө	447000	Тээврийн зардал, буудал, хоол, аялалын даатгал	Хамт олны багц, 10+1 хөтөлбөр, найзуудын багц
2	Хайнань	10 өдөр 9 шөнө	2100000		
3	Тайвань	10 өдөр 9 шөнө	1665000		
4	Вьетнам	10 өдөр 9 шөнө	2380000		
5	Тайланд	6 өдөр 5 шөнө	2500000		
6	Бали арал	11 өдөр 10 шөнө	2450000		
7	Эрэн-Жининь-Датун-Утай-Хөх хот	9 өдөр 8 шөнө	910000		
8	Эрэн-Хөх хот-Мөнгөн элс-Чингисийн онгон	7 өдөр 6 шөнө	815000		
9	Төнгөрийн хаалга Жан Жиа Жие	10 өдөр 9 шөнө	2200000		
10	Шиа Мөн	11 өдөр 10 шөнө	1700000		
11	Итгэлт хамба-Байгаль нуур	4 өдөр 3 шөнө	297000		
12	Манжуур	5 өдөр 4 шөнө	300000		

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158**

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ 90873012**

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлагч алба: **Н.ПУНЦАГБОЛД 88096454**

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН 96017873**

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ 99998796**

Маркетинг, зар сурталчилгааны алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710**

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ 99042510**

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхлэсэн **Б.ӨНӨРТОГТОХ**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ОНЦЛОХ УЛС ТӨР

Б.ЧОЙЖИЛСҮРЭН ҮНДСЭН ХУУЛЬ ЗӨРЧСӨН ҮҮ



Б.ЭРХЭС

2017 тавдугаар сарын 04-ны өдрийн чуулганаар Сангийн сайд Б.Чойжилсүрэн гэгч Валютын сангийн шахалтаас үүдэж Монголын баялаг дотоодын нэг ч банк санхүүгийн байгууллагаар дамжихгүйгээр гадагшаа гарах шийдвэр гаргуулахаар УИХ-ын 29 дүгээр тогтоолын 11 дүгээр заалтыг засварлах асуудлыг ажлын цаг дууссан хойно УИХ-д оруулж ирж байлаа. Тэр өдрийн чуулганы хэлэлцэх асуудалд огтхон ч багтаагүй байсан гэдэг. Улмаар УИХ-ын чуулганы үдээс хойшхи хуралдаанаар Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцээд засварлах гэж байхад Б.Чойжилсүрэн сайд “Монгол Улсын “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдах хүсэлтийг ОУВС хойшлуулчихлаа. Оюутолгой зэрэг том компаниудын эрх ашигт халдсан заалт оруулсан учраас хойшлуулж байна. Тиймээс энэ заалтаа эргэж харахаас өөр аргагүй боллоо” хэмээн өөрөө дур мэдэн тогтоолыг засч, УИХ-д оруулж ирсэн нь шүүмжлэл дагуулж байсан юм. Уг асуудлыг хэлэлцэж эхлэх үед УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэн “Сайд нь УИХ-ын тогтоолыг дур мэдэн засч болдгийг анх удаа харлаа. Тэр тусмаа нийм туршлагатай улстөрч хурал удирдаж байхад ийм зүйл гарч байна.

Наадах чинь Цэцэд очно шүү хэмээн сануулж байсан юм. УИХ-ын дэд дарга Ц.Нямдорж уг хуралдааныг даргалж байх үед энэ асуудлыг хэлэлцэж, улмаар 65.5 хувийн саналаар хэлэлцэн дэмжиж байлаа. Хуралдаанд оролцсон 55 гишүүнээс 19 татгалзаж, үлдсэн 36 нь хэлэлцэхийг дэмжсэнээр Валютын сангийн шахалтаар монголын баялаг гадагшаа хяналтгүй гарах тогтоол батлагдсан билээ. УИХ-ын гишүүн Н.Амарзаяа, О.Батнасан, Б.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, Х.Баделхан, М.Билэгт, Д.Дамба-Очир нарын 36 гишүүн дэмжиж, Д.Эрдэнэбат, Ц.Даваасүрэн, Д.Тэрбишдагва, С.Эрдэнэ, А.Сүхбат нарын 19 гишүүний татгалзан энэ тогтоолын өөрчлөлт яван явсаар Үндсэн хуулийн цэцэд очлоо. Өөрөөр хэлбэл, Ц.Даваасүрэн гишүүний хэлж байсан нь үнэн болж таараа. Энэ асуудлыг АН-ын бүлэг өнгөргөч даваа гарагийн хуралдаанаар хэлэлцэж, иргэн О.Алтангэрэл Үндсэн хуулийн цэцэд хандах болсон тул холбогдох материал гаргаж өгөхийг хүссэн гэдгийг дуулгасан. Тиймээс АН-ын бүлэг иргэний хүсэлтийг хүлээн авч шаардлагатай материалыг гаргаж өгнө гэдгээ мэдэгдсэн билээ.

Тэгвэл өчигдөр иргэн О.Алтангэрэл Үндсэн хуулийн цэцэд энэ асуудлаар хандлаа. Үндэслэлээ тэрбээр, “Үндсэн хуульд Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрхтэй гэж заасан байдаг. Гэтэл сайд Үндсэн хуулиа зөрчиж албан тоот бичиж, түүнийг нь байнгын хороо хүлээн авч, үүнийгээ чуулганаар хэлэлцүүлсэн. Улмаар 30 дугаар тогтоол гаргаж 29 дүгээр тогтоолын 11 дүгээр заалтыг

хүчингүй болгосон. Хоёрдугаарт, Монгол Улсын Үндсэн хуульд болоод үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Эдийн засгийн бие даасан байдлыг хангах замаар үндэсний аюулгүй байдлаа хангана” гэсэн байдаг. Тэгвэл бид бие даасан баймаар байна шүү дээ. Гэтэл энэхүү чухал заалтыг үгүй хийгээд, Үндсэн хуультай харшилсан олон тусамд шинэ зүйлтэй танилцаж дагаж мөрдөхгүй байх ёстой. Гэтэл “ОУВС-ийн захирлуудын зөвлөлийн хурал хойшлогдчихлоо” гэдэг зүйлээр монгол төр процессоо зөрчөөд, ийм шийдвэр гаргаж байгаа нь харамсалтай байна. Тиймээс би Үндсэн хуулийн цэцэд мэдэгдэл гаргаж байна” гэлээ. Хамгийн ноцтой нь 30 дугаар тогтоолын үр дүнгээс болж дан ганц Оюутолгой бус “Бороо гоулд”, “Центрра Гоулд”, Тавантолгой гэх мэт стратегийн ач холбогдол бүхий гадны хөрөнгө оруулалттай бүх уул уурхайн компанийн мөнгө ямар ч хяналтгүйгээр, Монголын эдийн засагт туй ч хамаарахгүйгээр хилээр гарах нь тодорхой болчихоод байгаа юм. Тиймээс Үндсэн хуулиас давсан эрх мэдэл эдэлж, тогтоолын төслийг дур мэдэн зассан Б.Чойжилсүрэнд хариуцлага тооцох асуудлыг ч ярихад гэмгүй болжээ. Олон улсын валютын сангийн шийдвэр өчигдөр шөнө эцэслэн гарсан. Гэвч Үндсэн хуулиас давсан, үндэсний эрх ашигт халдсан энэ шийдвэрийн хор нөлөө нэг удаагийн 5.5 тэрбум зээлээс ч аюултай үр дагавар учруулна гэдгийг иргэн О.Алтангэрэл онцолж байлаа. Цэц энэ асуудлыг хэлэлцэж, улмаар Үндсэн хуулиас давсан эрх мэдэл хэрэгжүүлсэн сайдын шийдвэр буруу байсныг нотолвол УИХ шийдвэрээ эргэж харахаас өөр аргагүйг хүрэх учиртай. Тэр цагт эрх баригчид улсынхаа цаашдын эрх ашгийг бодох уу, эсвэл Валютын сангаас айх айдасгайга хүлээгдэж, дараагийн 20, 30 жилийн ирээдүйгээ булаах уу гэдэг нь тодорхой болох учиртайг ч хэлж байсан юм.

захналга өгч эхлэх үедээ л хэдэн настай ямар хүүхэд явахыг урьдчилан мэдэгдэх хэрэгтэй. Хаашаа явах гэж байгаа ямар аялал вэ гэдгээс шалтгаалаад тухайн үеийн нөхцөл байдалтай нь уялдуулан хүүхдийн нас, сэтгэхүйд тохирсон хөтөлбөрийг аялалд нь шилтгэж өгдөг. Гадаад аялалд хүүхдүүд уйдах нь харьцангуй бага. Тоглоомын газар тоглох, усан парк орох гээд хүүхдийн сонирхол татах, цагийг зугаатай өнгөрөөх олон сонголт бий. Тиймээс хүүхэд уйдна гэхээсээ илүү жаахан ядрах гээд байдаг юм. Өдөр болгон, цаг мөч тусамд шинэ зүйлтэй танилцаж “Энэ юу вэ”, “Яадаг юм бэ” гээд сонирхож явдаг учраас тэр. Ахмадууддаа зориулаад шинээр их аятайхан аялалын хөтөлбөр гаргаж байгаа. Тухайлбал, Шанхай, Нянжин, Хөх мөрөн дагасан бүтэн сарын аялал бий. Энэ аялалаар явах хүн гурав хоног сайхан амраад хоёр

машинны шатахуун хийгээд явна гэсэн үг шүү дээ. Ийм үйлчилгээ хэрэггүй гэлээ гэхэд 10 хүнтэй автобусыг 2-3 машин дагаж явах болдог. Иймээс тээврийн зардал өндөр болно. Хэрэв 100-200, магадгүй үүнээс олон ажилтантай байгууллага байвал бид Авто тээврийн үндэсний төвтэй гэрээтэй хамтран ажилладаг учраас тэндээс автобус авч явдаг.

...Энэ мэтээр тэдний хийж хэрэгжүүлж буй ажил олон. Сүүлийн хэдэн жилийн турш тасраад байсан нэг өдрийн жуулчин хүлээж авах аялалыг ч тэд зохион байгуулж байна. Өнгөрсөн дөрөвдүгээр сарын 21-нээс Замын-Үүд дэх “Жинчин” төвдөө БНХАУ-аас ирэх нэг өдрийн жуулчдыг хүлээн авч буй юм. Нэг өдрийн жуулчид хилийн багана үзчихээд буцаад гардаг. Энэ жилдээ БНХАУ-аас 4800 нэг өдрийн жуулчин хүлээн авахаар төлөвлөжээ.

МЭДЭЭЛЭЛ



34 улсын намын дарга нар Монголд чуулна гэв

“Прогрессив Алианс” буюу Дэвшилтэт холбооны дөрөвдүгээр бага хурал энэ сарын 25-26-нд Улаанбаатарт болохтой холбогдуулан УИХ-ын гишүүн А.Ундраа, Д.Цогтбаатар, Г.Занданшатар болон “Прогрессив Алианс” байгууллагын ерөнхий зохицуулагч Константин Вайнофф нар өчигдөр Тусгаар тогтнолын ордонд мэдээлэл хийлээ. Дэлхийн зүүн төвийн үзэл баримтлалтай 130 улс төрийн намыг эгнээндээ нэгтгэсэн энэхүү нэгдэл нь социал демократ буюу нийгмийн ардчилсан үзлийг тэгүүн дэлгэрүүлэх зорилготой байгууллага аж. Тус холбооны дөрөвдүгээр бага хуралд Англи, Австрали, Швед, Португали, Гүрж, Герман, Бельги, Малайз, Марокко, Судан, Энэтхэг, Палестин зэрэг 34 улсын парламентын гишүүн, намын дарга болон удирдах төвшний ажилтнууд оролцохоор болжээ. Хурлын төлөөлөгчид нийгмийн тогтвортой байдал, шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, Азийн орнуудын хөгжиж буй байдал зэрэг сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэх юм байна.

ҮЗЭЛ БОДОЛ



“Энигма” компанийн эрх ашгийн төлөө жагсч буй оюутнууд

Дугаарын **60** мөр
Хайран 30 тэрбум төгрөг

Төгсгөл.
 Түрүүч нь I нүүрт

Ерөнхийлөгчийн ээлжит сонгуультай холбогдуулан Ерөнхий аудит Д.Хүрэлбаатарын гаргасан тушаалд дурдсанаар улс төрийн нам, эвслээс гарах зардлын дээд хэмжээг 6.8 тэрбум төгрөг, нэр дэвшигчээс гарах зардлын дээд хэмжээг 3.9 тэрбум төгрөг гэж тогтоожээ. Ерөнхийлөгчийн ээлжит сонгуульд улс төрийн гурван намаас тус бүр нэг хүн нэр дэвшч буй.

Эдгээр гурван намын хоёр нь эдийн засгийн хувьд түүртээд байхааргүй. Эрх барьж байгаагийн хувьд МАН энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгуульд айхгүй нь ойлгомжтой. УИХ-ын ээлжит сонгуульд нэр дэвшигчид хийгээд албан тушаал горилогсдоосоо хандив цуглуулсан гэдгийг нь ч ард түмэн мэдэж байгаа. Одоо түүнийгээ гаргах биз. Үнэн хэрэгтээ 6.8 тэрбум төгрөг гэдэг бага мөнгө биш. Гурван намын мөнгө нийлээд 20.4 тэрбум төгрөг. Ийм хэмжээний мөнгийг улсын төсөвт нийлүүлэх гэж зарим аймгийн Засаг дарга нар үсээ зулгааж буй. Бас үүнээс ч бага мөнгөөр жилийн турш ажиллаж амьдардаг аймаг Монголд нэлээд хэд бий.

Дээр нь гурван нэр дэвшигчийн 11.7 тэрбум төгрөгийн нэмэхээр 32.1 тэр бум төгрөг болно. Аагаа багтааж ядсанд нь 3.9 бус 9.3 тэрбум төгрөг ч юу ч биш санагдаж байж мэднэ. Сонгуулийн өмнөх болоод сонгуулийн өдөр нэр дэвшигчийн саналыг дор хаяж шил архи 30 мянган төгрөгөөр хондлаж авч таарна. Өмнөх УИХ-ын сонгуульд ийм тохиолдол хэдэн арваараа илэрсэн. Цаг тулахаар микро микроор нь хүнээ зөөж, зөөх замдаа мөнгөө тараадаг. Энэ бүх хууль бус үйлдэлд хэдэн арван сая төгрөгийг зарцуула. Нэр дэвшигчид ч аль хэдийнэ тооцож, түүнд зориулсан мөнгийг цүнхний буланд хийж л таараа. Бас нэр дэвшигчдэд тал засч, албан тушаал горилсон салбадаг нар хандив өргөж, хэдэн цаас сарвайцгаах нь бий. Бэл бэнчинтэй зарим нь нэг багийн сонгогчдын саналыг худалдаж авах зардлыг тань даая гээд харайлгаж яваа ч байж мэднэ. Тэгэхээр нэг нэр дэвшигчээс гарах зардал арван тэрбумаас хол давах нь дамжиггүй. Сүүлийн жилүүдэд бүхий л сонгууль мөнгөний болж хувирсан. Тэгэхээр монголчууд ийм их хэмжээний мөнгөөр тав дахь Ерөнхийлөгчийг сонгож таарах нь.

Хатуу хэлэхэд, сонгууль нэрээр салхинд хийсгэж орхих гээд байна. Харин сонгуульд зарцуулахаар төсөвлөсөн мөнгө хааш оддог вэ гэвэл мэдэж ихэнх нь сурталчилгаа болон тараах материалын хэвлэлт, шатахуунд урсч оддог. Тун бага хувь нь тойргийн хороо, хэсэгт ажилладаг ухуулагч нарын хөдөлмөрийн хөлст шингэдэг. Ялагдал хүлээсэн нэг нь мөнгөтэй хэрнээ, мөнгөгүй мурсын тохиолдол сонгууль бүрт гардаг атлаа халаасалж амжсан мөнгөө сонгуульд зарцуулсан байдлаар тайланд тусгаж, төрийг хуурдаг. Тайлан бол цаас. Сүүхээгэйхэн нягтлан бодогч Ерөнхий аудитын тогтоосон үнийн дүнд тааруулсан тайланг гаргаж чадна. Хүн ам цөөн, сонгогчдын бүхий л мэдээлэл цахимжсан, иргэд нь сонгууль өгөөд сурчихсан ийм нөхцөлд улс төрийн нам, нэр дэвшигч энэ тэр гэлгүйгээр нийт зардлын хэмжээг 6.8 тэрбум төгрөгт багтааж яагаад болохгүй гэж. Ингэж чадах аваас хорь гаруй тэрбум төгрөгөөр орон сууцны иж бүрэн хороолол хоёрыг, няхаст зориулсан халдвартын эмнэлэг эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан ерөнхий боловсролын сургуулийг хэд хэдэн аймагт барьж ашиглалтад оруулж болно шүү дээ.

Төгсгөл.
 Түрүүч нь I нүүрт

Тодруулбал, төрийн бодлого шийдвэрийг үл тоож өөрийн эрх ашгаа хамгаалуулахын тулд удирддаг сургуулийнхаа оюутнуудыг жагсаан эсэргүүцэл илэрхийлсэн “Энигма” компанийн бусармаг үйлдэл, цаашлаад Дархан цаазат газар аялалын зориулалтаар газар авсан атлаа газар ухан барилга барихаар санаархаж байсан “Аялж уул” компанийн асуудал очигдрийн дуулиан тарьсан сэдэв байсан юм. Эдгээр нь хоёулаа газрын маргаантай холбоотой. Тэр тусмаа Дархан цаазат газарт газар эзэмшчээд хууль бусаар өөр үйл ажиллагаа эрхэлж буй олон олон аж ахуйн нэгж, танил талтай иргэдийн тод томруун дүр төрхийг энэ хоёр асуудал илчилж өглөө.

Оюутнууд жагсаасан
 “Энигма” компанийн
 зорилго юу байв

Байгаль орчин аялал жуулчлалын яам өчигдөр Соёмбот ууланд газар эзэмшиж, ухаж эхэлсэн иргэний талаар мэдээлэл хийхээр сэтгүүлдийг цуглуулах үед гадна нь МУИС-ийн оюутнууд уриа дооон болсоор угтсан юм. Ямар шалтгаанаар тэд цугласныг тодруулахад нэг ч оюутан жагсч буй шалтгаанаа хэлж чадаагүй. Өөрөөр хэлбэл, сургуулийн захиргаа жагс гэсэн учраас энд ирсэн хэмээн ярьж байлаа. Тэгвэл эдгээр оюутнуудын эсэргүүцэл өөрсдийнх нь эрх ашгийн төлөө биш сургуулийн захирлынх нь компанитай холбоотой юмсанж. Тэр тусмаа Богд хан уулын Зайсангийн аманд 500 автомашины зогсоол барих шийдвэр гаргасан Засгийн газрын болон салбар яамны сайдын шийдвэрийг эсэргүүцэн жагсаал хийжээ. Үйл явдлыг эргэн сануулвал, БОАЖ-ын сайд Д.Оюунхорол нийслэлийн иргэдийн хамгийн их амарч зугаалдаг, Богд уулын аманд нийтийн бие засах газар, амарч суух сандал, кофе шоп бүхий 500 автомашины зогсоол барих шийдвэрийг гаргасан. Жилийн дөрвөн улиралд дунджаар 10 гаруй мянган иргэд аялах

зорилгоор Богд уулыг зорьдог учраас тэдгээр иргэдийн эрх ашгийн төлөө гаргасан шийдвэр нь олны талархлыг хүлээгээд байлаа. Нийтийн бие засах газаргүйгээс хаа таарсан газраа бие засч, хогоо хаяж байгаагаас Богд уул орчмын дархан цаазат газрын ой мод бохирддог, мөн автомашинаа зам дагуу тавьж уул өөдөө алхдаг учраас Зайсан орчмын машины түгжрэл иргэдийн бухимдлыг төрүүлээд байсан юм. Тиймдээ ч төрийн шийдвэр гарч, аялал жуулчлалын бүсийг тохижуулах шийдвэрт хүрсэн нь эдгээр оюутнуудыг эсэргүүцэл зарлах шалтгаан болжээ. Нэгдсэн зогсоол барихын тулд тус бүсэд 42 га газар эзэмшдэг “Энигма” компанийн эзэмшлийн газраас гурван га газрыг төрийн эзэмшилд авах шийдвэрийг Д.Оюунхорол сайд гаргажээ.

Гэтэл “Энигма”-ийн удирдлага яаран сандран тус газраа сургуулийн барилга барьж, мод суулгаж эхэлжээ. Улмаар шийдвэр гарсны дараа энэ бүхнийг эхлүүлж авсан атлаа бидний сургууль барих газрыг Д.Оюунхорол сайд хүчээр булааж авлаа хэмээн шуудаж, учраа ойлгохгүй оюутнуудыг улс төрийн зорилгоор ашиглаж эхэлсэн нь энэ юм байна. Энэхүү тэмцээс үүдэн “Энигма” гэж ямар компани болох, энд оюутнууд ямар хамаатайг ухаж үзэв. Тэгвэл “Энигма” гэх компани нь Солонгосын хөрөнгө оруулалттай бөгөөд аялал жуулчлал, боловсролын салбарт үйл ажиллагаа явуулдаг аж. Монгол талын захирлаар Л.Мөнхбат гэгч ажилладаг бөгөөд дээрх дархан цаазат газарт үйл ажиллагаа явуулж буй “Чингисийн хүрээ” жуулчны бааз, МУИС түүний эзэмшлийнх юм байна. Тиймээс өөрийнх нь жуулчны баазын эрх ашиг хөндөгдсөн учраас сургуульд нь төлбөр төлөн суралцаж буй түмний үрсийг хүчээр шахуу жагсаан төрийн шийдвэрийн эсрэг том толгой гаргасан нь тэр аж. “Энигма” үнэхээр энэ газарт сургууль барих гээгүй, хэдхэн шавар хугацаанд “Чингисийн хүрээ” гэх амралтын газар ажиллуулж байснаас харагдаж буй юм. Бие засах газар байхгүй, хэдхэн шавар гэр барьчихсан энэ газраа сургууль барихаар хадгалж байсан хэмээн

улайрч буйн инээдэмтэй. Төрийн шийдвэрийг үл тоож, хоёр гэрлийн шонгийн мод хатгасны төлөө жагсаал цуглаан хийж буй энэхүү компанийн үйл ажиллагаанд БОАЖ-ын яамнаас шалгалт хийхэд маш олон зөрчил илэрсэн нь нотлогдсон юм.

Тодруулбал, сүүлийн хоёр жил газар ашигласны төлбөрөө төлөөгүй байсан аж. Хуулиараа улсын тусгай хамгаалалттай газарт үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий этгээд нэг жилд 1 га газарт 13.2 сая төгрөгийн төлбөр төлөх ёстой аж. Ингэж тооцвол “Энигма” ХХК-ийнхан тэрбумгаруй төгрөгийн өр төлбөртэй гэсэн үг. БОАЖ-ын Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын мөргөжилтэн Ч.Галын хэлж буйгаар барилгын зураг төсөв юу ч батлуулаагүй атлаа гадны хөрөнгө оруулалтаар сургууль барина хэмээн барилгын шав тавьсан, мөн газар ашигласны төлбөрөө төлөөгүй эзрэг ноцтой асуудал гаргажээ. Нийслэлийн удирдлагууд энэ ажлыг наадмаас өмнө дуусгаахаар төлөвлөж, төсөв мөнгийг нь хүртэл шийдчихээд байсан аж. Гэтэл хоёр шонгийн мод хатгах газрыг төр эзэмшилдээ авснаас үүдэн энэ ажил зогсоход хүрээд байгаа юм. Гэхдээ нийтийн эрх ашгийн төлөө хийж буй энэ ажлаа үргэлжлүүлээсэй гэсэн нийгмийн хүлээлт талаар өнгөрөхгүй гэж найдъя. Төр төмөр нүүрээ харуулж, 42 га газрынх нь асуудлыг хөндөхөд ч буруудах юун.

Н.Батцэрэгт хариуцлага
 тооцье

Хоёрдугаар дуулиан дагуулсан асуудал бол БОНХАЖ-ын сайдаар ажиллаж байсан Н.Батцэрэгтэй холбоотой. Тодруулбал, бидний нэрлэж заншсан “Умаа хум” толгой буюу өдгөө монгол төрийн Соёмбыг тэргүүнд нь залсан тусгай хамгаалалттай уулыг мягмар гарагаас эхлэн ухаж эхэлсэн зураг сошиал ертөнцөд тарж эхэлсэн билээ.

Энэхүү газрыг эзэмшиж буй иргэн газар эзэмших зөвшөөрөлтэй хэмээн мэдэгдэж, төрийн тавьсан шийдвэрийг биелүүлэхээс

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Тендер шалгаруулалтын нэр: Гэр хорооллын үерийн хамгаалалтын суваг
 Тендер шалгаруулалтын дугаар: ОР-155/2017
 Огноо: 2017-05-24

Орхон аймгийн засаг даргын тамгын газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос Гэр хорооллын үерийн хамгаалалтын суваг хийх ажил-ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 100,000 /нэг зуун мянган/ төгрөгөөр худалдан авч болно.

Тендерийн баримт бичгийн үнийг доорхи дансаар тусана.

Төрийн сан 9025
 Дансны дугаар: 100210051424
 Хүлээн авагч: ОР.ОНӨГ нэмэлт санхүүжилт
 Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:
 Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын нийлбэрийн дундаж хэмжээ нь

санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх
 Санал болгож буй үнийн дүнгээс багагүй хэмжээний түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон эзэл авах боломжтой байх

2014, 2015, 2016 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх
 Дараах тусгай зөвшөөрөлтэй байх: Барилга хот байгуулалтын яамны 2.3.2-Хөрсний ус доошуулах, шүүрүүлэх, эргийн бэхлэгээ, далан суваг үүний дотор төмөр замын далан, хоолой болон газар шорооны тусгай ажил

Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн [1%] төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.
 Тендерийг 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 08 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байгуулан тендерийг 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 08 цаг 30 минутанд нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.
 Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Орхон аймгийн ЗДТГ, Нутгийн удирдлагын ордон
 1 давхар 113 тоот өрөө Утас:70358570

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Тендер шалгаруулалтын нэр: Гэр хорооллын үерийн хамгаалалтын суваг (I-р хэсэг)
 Тендер шалгаруулалтын дугаар: ОР-73/2017
 Огноо: 2017-05-24

Орхон аймгийн засаг даргын тамгын газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос Гэр хорооллын үерийн хамгаалалтын суваг (I-р хэсэг) ажил-ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 100,000 /нэг зуун мянган/ төгрөгөөр худалдан авч болно.

Тендерийн баримт бичгийн үнийг доорхи дансаар тусана.

Төрийн сан 9025
 Дансны дугаар: 100210051424
 Хүлээн авагч: ОР.ОНӨГ нэмэлт санхүүжилт
 Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:
 Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын нийлбэрийн дундаж хэмжээ нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх
 Санал болгож буй үнийн дүнгээс багагүй хэмжээний

түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон эзэл авах боломжтой байх

2014, 2015, 2016 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх
 Дараах тусгай зөвшөөрөлтэй байх: Барилга хот байгуулалтын яамны 2.3.2-Хөрсний ус доошуулах, шүүрүүлэх, эргийн бэхлэгээ, далан суваг үүний дотор төмөр замын далан, хоолой болон газар шорооны тусгай ажил

Тендерийн хамт санал болгож буй үнийн дүнгийн [1%] төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 08 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байгуулан тендерийг 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 08 цаг 30 минутанд нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.
 Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Орхон аймгийн ЗДТГ, Нутгийн удирдлагын ордон
 1 давхар 113 тоот өрөө Утас:70358570

ГОВЬСҮМБЭРИЙН МЭДЭЭ



“ШИЛДЭГ ГЭР БҮЛ”-ИЙГ ШАЛГАРУУЛЖЭЭ

VIII нүүрт

ХҮҮХЭД, БАГАЧУУДЫН НӨХӨР
“ТООДОЙ ХҮҮ”

VIII нүүрт

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

Т.БАТ-ЭРДЭНЭ: ЭНЭ ЖИЛ ГУРВАН ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛ ХИЙНЭ



Н.БАТЗАЯА

Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Т.Бат-Эрдэнэтэй Говьсүмбэр аймгийн хөрөнгө оруулалт болон хөгжлийн бодлогын талаар ярилцлаа.

-Говьсүмбэр аймагт урт болон богино хугацааны хөгжлийн бодлого тодорхойлсон байгаа шүү дээ. Ер нь Говьсүмбэр аймаг хөгжлийн бодлогоо хэрхэн харж байна вэ?

-Манай аймаг урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогоо тодорхойлж, ерөнхий

төлөвлөгөөгөө гаргасан. Бид аймгийнхаа тэргүүлэх чиглэлд хэд хэдэн салбарыг тодорхойллоо. Тухайлбал, нэн тэргүүнд аймагтаа хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлнэ. Мөн аялал жуулчлал, үйлдвэржилтийг хөгжүүлэхээр төлөвлөдөг байгаа. Манай аймаг газар зүйн байрлал, дэд бүтцийн

хувьд Монгол Улсын хамгийн боломжтой газар нь байрладаг. Нэгдүгээрт, Хөрш хоёр улсын уулзах гол төв цэг нь манай аймаг болж таараад байгаа юм. Сүүлийн үед гурван улсын эдийн засгийн коридорын асуудал их яригдлаа. Энэ хүрээнд гурван улсыг дамнасан аялал жуулчлал, тээвэр ложистик хөгжино. Үүний гол буудаллах цэг нь манай аймаг болоход их тохиромжтой. Учир нь аль ч талаасаа 500 км зайд оршдог. Өөрөөр хэлбэл, БНХАУ-аас манай аймаг хүртэл 500 км-ийн зайтай. Мөн ОХУ-аас ч 500 км-ийн зайд байрладаг. Ингэхээр тээврийн үйлчилгээ хүргэж буй жолооч нар буудаллаад дараагийнхаа улс руу явах

боломжтой. Зөвхөн орон зайн хувьд гэлтгүй олон улсын шинж чанартай авто зам, эрчим хүч, төмөр зам гэх мэтчилэн бүх дэд бүтэц Говьсүмбэр аймгаар дайран өнгөрч байгаа учраас цаашид тээвэр ложистикийн үйлчилгээг тулгуурлан хөгжих боломжтой гэж харж байгаа. Бидний дараагийн хүлээлт үүсгэсэн томоохон бүтээн байгуулалт нь “Шивээ овоогийн нүүсний орд” түшиглэсэн эрчим хүчний цогцолбор төсөл” юм. Энэхүү төслийн хүрээнд асар том бүтээн байгуулалтын ажлууд өрнөнө.

Үргэлжлэл нь VI нүүрт

Урилга

Говьсүмбэр аймгийн “Сүмбэр Гарден” соёл, спорт, амралтын хүрээлэнгийн менежментийг хариуцан үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулна.

Аж ахуйн нэгжид тавигдах шаардлага:

- Соёл, спорт, амралтын хүрээлэнд тасралтгүй, тогтвортой үйл ажиллагаа явуулах.
- Менежментийн гэрээнд тусгагдсан эрх үүргийг биелүүлж, төрийн байгууллагатай нягт уялдаатай хамтран ажиллах.
- Соёл, спорт, амралтын хүрээлэнд эрүүл ахуй, ариун цэврийн болон хөдөлмөр хамгааллын дүрмийг мөрдүүлэн ажиллах.
- Үндсэн үйл ажиллагааг сонгон шалгарсан аж ахуйн нэгж биечлэн удирдаж зохион байгуулах бөгөөд талбайн ашиглалт, үйлчилгээний чанарыг сайжруулах үүднээс хэд хэдэн аж ахуйн нэгжтэй шалгарсан иргэн, аж ахуйн нэгж гэрээ байгуулан ажиллах боломжтой.
- Шалгарсан аж ахуйн нэгж 20.000.000 төгрөгийн өртөг бүхий үл хөдлөх хөрөнгийг барьцаа болгож гэрээнд хавсаргана.

Ирүүлэх шаардлагатай бичиг баримт:

- Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотиратаар баталгаажуулсан/
 - Соёл, спорт амралтын хүрээлэнг түшиглэн явуулах үйл ажиллагааны танилцуулга. Менежментийн төлөвлөгөө, холбогдох тооцоо судалгаа.
 - Тоног төхөөрөмжийн жагсаалт, холбогдох зураг
 - Өөрийн үйл ажиллагааны танилцуулга
- Бичиг баримт хүлээн авах хугацаа: 2017 оны 06 дугаар сарын 05-ны 12:00 цаг хүртэл

Бичиг баримт хүлээн авах газар:

Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газрын 4 давхар 401 тоот, утас: 99025528, 99015926

МЭДЭЭЛЭЛ

“Боржигин голомт цогцолбор”-ыг байгуулна



“Боржигин голомт цогцолбор”-ыг байгуулах төслийг танилцууллаа. Энэхүү төсөл хэрэгжсэнээр түүх соёлын дурсгалт өвөө хамгаалахаас гадна аялал жуулчлалын цогцолбортой болж иргэд аж ахуйн нэгж байгууллага, аялал жуулчлалаас орлого олох боломж нэмэгдэх, ирээдүй хойч үедээ Боржигин өв соёлоо сурталчлах, хадгалж хамгаалах, судлах боломжууд нээгдэж төрөл бүрийн эвент арга хэмжээнүүд зохион байгуулагдаж, цаашлаад тасралтгүй хөгжих ач холбогдолтой ажээ.

Төслийн санаачлагч Т.Болдбаатар “Боржигин сумдад байгаа түүхийн дурсгалт өв болох Боржигин байшингуудыг нэгтгэн байрлуулах, байшинг сэргээн засварлах замаар “Боржигин байшин” хүрээ үүснэ. Тэрхүү дурсгалт цогцолбортоо түүх соёлын биет болон биет бус өвийн танилцуулга үзмэр бэлтгэх, Боржигин сумдын аялал жуулчлалын талаарх мэдээллийг байршуулах, иргэдэд өөрсдийн ураг овгийн бахархлыг алдаршуулах боломжийг нээж өгөх зорилготой юм. Мөн энэ цогцолбороор дамжин олон төрлийн соёл, аялал жуулчлалын гарцуудыг нээх боломжтой гэж үзэж байгаа. Төсөлд Монгол туургатан хэн ч оролцож болох бөгөөд оролцогч талууд хэдий чинээ өргөн хүрээтэй байна Боржигин хүрээ төдий чинээ том болж нөгөө талаас энэ нутгийн түүх соёлын нэгэн дурсгал хамгаалагдаж үлдэх ач холбогдолтой. 100-200 гаруй байшин цогцлоосон эртний суурин босч ирэх юм” гэв.

СПОРТЫН БАГА НААДМЫН ЭРГЭН ТОЙРОНД...

“Спортын бага наадам” -ын ЦОМЫН ЭЗЭД ТОДОРЛОО

Б.ЭНХЖИН

Говьсүмбэр аймгийн Засаг даргын нэрэмжит “Нэг санаа – Нэгдмэл хүч амжилтад хөтөлнө” уриатай “Спортын бага наадам” 10 хоногийн турш амжилттай болж өндөрлөлөө. Бага наадмын нээлтийн үйл ажиллагаа энэ сарын 5-нд Говьсүмбэр аймгийн Биений тамир, спортын газрын зааланд болов. Нээлтийн үйл ажиллагаа Говьсүмбэрчүүдийг үргэлж сүр жавхлантай олимпын галт бамбар адил дүрэлзэн асаж ажил үйлс нь бүтэмжтэй байх, аймаг орон нутгийн иргэд байгууллага хамт олон нэгэн тугийн дор нэгдэж төрөлх аймгаа хөгжүүлэх утга санааг илэрхийлэн Нутгийн удирлагын ордноос олимпын галт бамбарыг залснаар ёслол төгөлдөр эхэлсэн юм. Тус наадмын нээлтийн үйл ажиллагаанд Говьсүмбэр аймгийн Засаг дарга Г.Батсуурь, Засаг даргын орлогч Ш.Билэгтүмбэрэл, ИТХ-ын дарга Г.Батзям, Иргэдийн Хурлын Төлөөлөгчид, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга Ж.Оюунбилэг, аймгийн ЗДТГ-ын



Нийгмийн бодлогын хэлтсийн дарга С.Уранцэцэг, аймгийн Биений тамир, спортын газрын дарга, МУТДасгалуулагч Л.Цэдэнсодном нар оролцлоо. Наадмыг нээж аймгийн Засаг дарга Г.Батсуурь “Манай аймгийн хувьд биений тамир,

спортыг хөгжүүлэхэд тогтмол анхааран ажиллаж ирсэн билээ. Үүний үр дүнд бүс, улсын аварга шалгаруулах тэмцээнд тогтмол амжилттай оролцож авдаг медалийн тоо, төрөл тогтмол өссөөр байна. Зөвхөн энэ он гарсаар Шатар сонирхогчдын

дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс Говьсүмбэр нутгийн унаган хүү Бяруузанын Боорчи алт, мөнгөн медаль хүртэж, нийт бат тамирчид улсын аварга шалгаруулах тэмцээнээс 22 медаль хүртээд байна.

Үргэлжлэл нь VI-VII нүүрт

ГОВЬСҮМБЭРИЙН МЭДЭЭ

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

Т.БАТ-ЭРДЭНЭ:

Энэ жил гурван тэрбум төгрөгөөр бүтээн байгуулалтын ажил хийнэ

Үргэлжлэл.
Түүрч нь V нүүрт

Уг төсөл манай аймагт хэрэгжсэнээр 20 орчим мянган түр ажлын байр, 3000 байнгын ажлын байр 2021 он гэхэд бий болохоор яригдсан. Цогцолбор төсөл хэзээ батлагдаж ажил болохыг хэлж мэдэхгүй ч бид нэлээд ач холбогдол өгч, ирэх дөрвөн жилийнхээ бодлогын баримт бичгийг тодорхойлсон байгаа. Төсөлд суурилж дэд бүтэц, хотжилт, үйлдвэржилтийн бодлогоо тодорхойлохоос гадна жижиг дунд үйлдвэрлэлүүд ч энэ төслийг дагаж нэлээд хөгжиж, өргөжин хэмээн харж байна.

байгаа. Өнөөдрийн байдлаар автозамын сан, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөгдсөн ажлуудын тендер шалгаруулалт нь дуусч, гэрээ байгуулах шатандаа явж байна. Энэ онд автозамын сангаар гурван ажил хийхээр төлөвлөсөн. Тодруулбал, Засаг даргын Тамгын газрын урд зогсоол барих, дөрвөн замын уулзвараас Хэлмэгдэгсдийн хөшөө хүртэлх авто замын дагуух гэрэлтүүлгийн засварлаж, шинэчлэх, Хонхор хотонд 100 метрт автозамын өргөтгөнөө. Харин байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга



...Одоо бол тэр хэсэг хогийн цэг болчихсон. Гэхдээ тэнд цугласан хур хогийг цэвэрлээд 60.8 га газрыг үйлдвэржилтийн бүс болгож хөгжүүлнэ. Түүнээс цааш эрчимжсэн мал аж ахуйн бүс болгон хөгжүүлэх 70 гаруй га газрыг баталсан. Хүлэмжийн аж ахуй эрхлэх сонирхолтой болон хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хүмүүс байхаар бодож газрыг нь хуваариллаа...

Тэргүүлэх чиглэлийн нэг хэсэг нь аялал жуулчлалын салбар. Бидэнд Хэнтий, Хөвсгөл гээд бусад аймгуудтай өрсөлдөх хэмжээний аялал жуулчлалын нөөц байхгүй. Мөн аялал жуулчлалыг хөгжүүлнэ гээд төсвөөс мөнгө гаргаж том цогцолборыг бий болгох тухай ойлголт бүр байхгүй. Харин уламжлалт хөдөө аж ахуйд суурилсан аялал жуулчлалыг хөгжүүлэх тухай хөгжлийн бодлогоо тусгасан. Манай аймагт түүх соёлын дурсгалт газар болох Чойрын богд уул, Зүүн жанжин Чойрын хийд гэх мэтчилэн үүх түүхтэй газрууд байдаг. Эдгээр газруудаа түшиглэсэн аялал жуулчлалын баазуудыг бий болгохоос гадна малчдаа дэмжих үүднээс уламжлалт мал аж ахуйг түшиглэн аялал жуулчлалаа хөгжүүлнэ. Нэг их төсөв, мөнгө шаардахгүйгээр энэ чиглэлээр юм хийе гэсэн иргэдийг дэмжин ажиллах замаар аялал жуулчлалын салбараа хөгжүүлэх юм.

Хөрөнгө оруулалтын чиглэлээр ямар ажлууд хийгдэх вэ. Хэчнээн төгрөгийн хөрөнгө оруулалт орж ирвэ?

Тавдугаар сарын 5-нд төсвийн тодотголоо хийлээ. Орон нутгийн хөгжлийн санд хоёр тэрбум 43 сая 306 мянган төгрөгийг тодотгосон. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 79 сая төгрөг, автозамын санд 46.9 сая төгрөгийг оны өмнө баталсан. Мөн энэ жил улсын төсвөөс 649.9 сая төгрөгийн ажлын эрхийг шилжүүлж, орон нутагт худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар болсон. Үүний ихэнх нь нийгмийн салбарын барилга байгууламжийн засвар үйлчилгээ, тоног төхөөрөмж худалдажавахаар төлөвлөгдсөн

хэмжээний зардалд гол горхн, булаг шандын эхийг хамгаалах, ус нөөцлөх сав суурилуулах, худга гаргах, усны зөөврийн автомашин худалдан авах гээд нилээдгүй ажил төлөвлөсөн. Орон нутгийн хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар аймгийн төвийг теле камерын системд холбох, нэг наймдугаар байрны фасад, 15-р байрнаас Хөдөлмөр, халамж, үйлчилгээний хэлтэс



Биеийн тамир, спортын цогцолбор ордны холболтын зураг төсөө

хүртэлх авто болон явган хүний зам, тоглоомын талбай засварлах гэх мэт нэлээд ажлууд хийхээр төлөвлөв. Эдгээр ажлууд эхнээсээ гүйцэтгэгч нь шалгарч ажлаа эхлүүлсэн байгаа. Худалдан авах ажиллагааг төлөвлөгөөний дагуу хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж байна.

Гадаад харилцааны чиглэлд ямар бодлого барьж байна. Хамтын ажиллагааны хүрээнд хийгдсэн, хийхээр төлөвлөж буй ажлуудаасаа танилцуулахгүй ю?

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Зүүн сөнөд хошуутай хамтарч ажиллах гэрээ байгуулсан. Энэ хүрээнд боловсрол, хөдөө аж ахуйн салбарт илүү хамтран ажиллах хүсэлтэй

байгаагаар уламжилсан. Манай аймагт Уул уурхайн жишиг Политехникийн коллеж байдаг. Энэ коллежийн багш, оюутнуудыг Шилийн гол аймаг дахь ижил төстэй сургуульд солилцоогоор суралцаж, туршлага судлах, хөдөө аж ахуйн салбарт эрчимжсэн мал аж ахуйн чиглэлд хамтран ажиллах саналыг тавьсан. Мөн Япон улсын Элчин сайдын яамтай нэлээдгүй хамтарч ажиллаж ирсэн. Япон улсын "Өвсний үндэс" хөтөлбөр төслөөс сүүлийн гурван жил төсөл бичиж, хамтран ажилласан. Энэ онд V сургуулийн гадна фасад болон дотор засварын ажлын төслийг дэмжиж, ажил нь хүлээлгэн өгөхөд бэлэн болсон байгаа. Энэ сургуулийн дотуур байранд

казарм байсан. Одоо бол тэр хэсэг хогийн цэг болчихсон. Гэхдээ тэнд цугласан хур хогийг цэвэрлээд 60.8 га газрыг үйлдвэржилтийн бүс болгож хөгжүүлнэ. Түүнээс цааш эрчимжсэн мал аж ахуйн бүс болгон хөгжүүлэх 70 гаруй га газрыг баталсан. Хүлэмжийн аж ахуй эрхлэх сонирхолтой болон хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хүмүүс байхаар бодож газрыг нь хуваариллаа. Өнгөрсөн жил эрчимжсэн мал аж ахуйн бүсэд худга гаргаж, цахилгаан эрчим хүчний асуудлыг нь шийдвэрлэсэн. Энэ жил дахин нэг худга гаргаад байна. Хонхор хотхоноос зүүн урд чиглэлд "Хаус" хороолол байгуулахаар төлөвлөсөн байгаа. Хамгийн өртөг багатай, таун хаус хэлбэрийн байшинг 2020 он хүртэл үе шаттайгаар барина. Харин орон сууцныг Хонхор хотхоноосоо хойд чиглэлд барих юм. Тухайлбал, аймаг бүрт баригдаж буй 1000 айлын орон сууцныг Соёл, амралтын хүрээлэнгийн замын эсрэг талд баригдахаар зураг төсөл нь гарчихсан.

Сүүлийн үед Улаанбаатар хот гэлтгүй хөдөө орон нутагт ч агаарын бохирдолтой холбогдуулаж орон сууцжуулах бодлого баримталж байна. Энэ талаар ямар ажил хэрэгжүүлэхээр төлөвлөв?

Салхигүй тогтуун үед гэр хорооллын утаа Хонхор хотхон руу ороод ирчихдэг. Тиймээс энэ онд агаарын чанарын судалгааны судалгааг үе шаттай хийж байгаа. Ер нь нийтэд нь орон сууцанд амьдардаг. Бусад аймгийг бодвол харьцангуй гэр хороолол багатай. Гэхдээ жил ирэх тусам шилжилт, хөдөлгөөн нэмэгдэж байна. Улаанбаатар хоттой ойрхон, дэд бүтэц хөгжсөн гэдэг үүднээс шилжиж ирж буй хүмүүс бий. Гэр хорооллын айлууд нэмэгдэхээр дагаад утаа ихсэнэ. Тиймээс аймгийн хэмжээнд орон сууцжуулах бодлого барьж, шат дараатай ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

СПОРТЫН БАГА НААДМЫН ЭРГЭН ТОЙРОНД...

“СПОРТЫН

Үргэлжлэл.
Түүрч нь V нүүрт

Мөн Орон нутагтаа “Говьсүмбэр мастер кросс-2017” авто машины бартаат замын уралдааныг зохион байгуулж Монголын авто спортын бүхий л шилдэг тамирчид оролцон өрсөлдлөө. Өрсөлдөөн дундаас Баянтал сумын уугуул П.Баярхүү залуучуудын ангилалд хоёрдугаар байр эзэллээ. Түүнчлэн хөлбөмбөгийн зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулж хоёр насны ангилалд аймгийн баг тамирчид тэргүүлсэн бол футзалны талын бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг мөн зохион байгуулж хоёр насныхаа ангилалд дэд байрт шалгарсан амжилтыг үзүүллээ. Сагсан бөмбөгийн “Чойр хөгжлийн лиг-2017” тэмцээнийг залуучууд, эмэгтэйчүүд, +30 насны ангилалаар зохион байгуулж 19 багийн 270 гаруй тамирчид оролцон хоёр сарын турш өрсөлдөж аваргуудаа тодрууллаа. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Биеийн тамир, спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх, биеийн тамир, спортын цогцолбор байгуулах, биеийн тамир, спортын материаллаг баазыг бэхжүүлэх ажлуудыг тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа. Цаашид эдгээр бий болсон спортын байгууламж, тоног төхөөрөмж материаллаг баазыг түшиглэн нийтийн биеийн тамир, спортоор хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх, эрүүл чийрэг бие бялдартай иргэдийг төлөвшүүлэх нь бидний авч хэрэгжүүлэх чухал зорилтуудын нэг юм. Иймд энэ зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдэж байгаа нэг ажил бол өнөөдөр нээлтээ хийж байгаа аймгийн Засаг даргын нэрэмжит “Спортын бага наадам” юм. Энэ удаагийн наадмын онцлог нь спортын найман төрлөөр тэр дундаа хөлбөмбөг, үндэсний бөхийн төрлийг нэмж оролцуулснаараа онцлог юм. Цаашид уг наадмыг хоёр жил тутамд зохион байгуулж, төрлийг нэмэгдүүлэх, чанаржуулахад анхаарч ажиллах болно. Нийт баг тамирчид, хөгжөөн дэмжигчид, энэхүү тэмцээнд баг хамт олноо бэлтгэн оролцуулж байгаа байгууллагын удирдлагуудаа спортын өндөр амжилт хүсье. Аймгийн Засаг даргын нэрэмжит “Спортын бага наадам” нээснийг мэдэгдье” гэв.

МОУХ–ны медалиар 10 тамирчныг шагнаж, урамшууллаа

Нээлтийн үйл ажиллагаа хүндэтгэлийн тоглолтоор үргэлжилсэн юм. “Спортын бага наадам”-д оролцож буй шилдэг баг, тамирчиддаа Цагдаагийн Сүлд чуулгын гоцлол дуучин, МУСТА Ц.Амарболд аймгийн хүндэтгэлийн дуугаар ая дууны мэндчилгээ дэвшүүлсэн бол Боржигин чуулгын дэргэдэх “Хөх толботон” хамтлаг, бүжигчид Алтайн магтаалыг сонирхууллаа. Мөн нээлтийн үйл ажиллагааны үеэр орон нутагтаа их спортыг хөгжүүлэх, ирээдүй Спортын боловсрол олгох, олимпын хөдөлгөөнийг сурталчлан дэлгэрүүлэх их үйлсэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж тус аймгийн Засаг дарга Г.Батсуурь, аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн соёл, спорт, төрийн бус байгууллага хариуцсан ахлах мэргэжилтэн Г.Анхбаатар нарыг Монголын Үндэсний олимпын хорооны дээд шагнал “Олимпын алдар” одонгоор шагнасан юм. Мөн волейболын “Спортын мастер” цол, тэмдгээр Политехникийн коллежийн биеийн тамирын багш Л.Энхмөнх, “Спортын дэд мастер” цол, тэмдгээр аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн тамирчид болох нэгдүгээр сургуулийн 12а ангийн сурагч Г.Номинсүвд, М.Одмаа, тавдугаар сургуулийн 12в ангийн сурагч С.Будсүрэн, Ч.Номин-Эрдэнэ, 12б ангийн Э.Ундрахбаяр нарыг шагнаж, урамшууллаа. Харин Пара-волейболын “Спортын дэд мастер” цол, тэмдгээр аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны тэргүүн, Д.Бадамханд, П.Ганбилэг, Х.Ариунзаяа нарыг тус тус шагнаснаар нээлтийн үйл ажиллагаа өндөрлөсөн юм.

“Спортын бага наадам” сагсан бөмбөгийн тэмцээнээр эхлэв



Бүх нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, хүүхэд залуусын бие бялдрыг сайжруулах, ирээдүйн залуу тамирчдыг тодруулах зорилгын хүрээнд зохион байгуулагдаж буй Говьсүмбэр аймгийн Засаг даргын нэрэмжит “Спортын бага наадам” эхний долоо хоногт сагсан бөмбөг, Шатар, Усан сэлэлтийн тэмцээнээр эхэлсэн юм. Сагсан бөмбөгийн тэмцээн аймгийн Биеийн тамир, спортын газар, Политехник коллежийн зааланд гурван өдрийн турш болж аваргуудаа тодрууллаа. Тус тэмцээнд эрэгтэй 20, эмэгтэй 19 багийн 310 гаруй тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөв. Ийнхүү эрэгтэйчүүдийн төрөлд Л.Даваадорж ахлагчтай “Сансар” баг тэргүүн байр эзэлсэн бол Б.Зориг-Эрдэнэ ахлагчтай “Шонхор” баг удаалжээ. Харин Ч.Бат-Эрдэнэ ахлагчтай “Илч” баг гуравдугаар байрт шалгарлаа. Эмэгтэйчүүдийн төрөлд нэгдүгээр байрт Ц.Энхчимэг ахлагчтай “Банкууд” баг, хоёрдугаар байрт н.Соёлмаа ахлагчтай “Ганзам” баг, гуравдугаар байрт О.Бэрцэцэг ахлагчтай “Бизнес хөгжил” баг тус тус шалгарсан юм. Мөн сагсан бөмбөгийн тэмцээний үеэр шилдэг хамгаалагч, шилдэг довтлогч нарыг шалгаруулсан. “Шилдэг хамгаалагч”-аар эмэгтэйчүүдээс “Ганзам” багийн тамирчин Б.Алтанзул, эрэгтэйчүүдээс “Сансар” багийн тамирчин Л.Даваадорж, “Шилдэг довтлогч”-оор эмэгтэйчүүдээс “Банкууд” багийн тамирчин Ц.Энхчимэг, эрэгтэйчүүдээс “Шонхор” багийн тамирчин С.Мөнх-Эрдэнэ нар шалгарлаа.

ГОВЬСҮМБЭРИЙН МЭДЭЭ

БАГА НААДАМ"-ЫН

ЦОМЫН ЭЗЭД ТОДОРЛОО

Шатрын тэмцээнд 33 тамирчин өрсөлджээ



“Спортын бага наадам”-ын шатрын тэмцээнд 18 багийн нийт 33 тамирчин оролцож, аваргуудаа тодруулаа. Тэмцээн эрэгтэй, эмэгтэй гэсэн хоёр ангилалд зохион байгуулагдсан юм. Тус тэмцээний нэгдсэн дүнгээр “Бизнес хөгжил баг” хоёр ангилалд аваргалж тэргүүлсэн бол “Эрчим” багийн шатарчид хоёр ангилалд дөрөвдүгээр байрт шалгарснаар дэд байр эзэлсэн. Харин “Замчин” багийн шатарчид эрэгтэйтэйчүүдийн ангилалд тавдугаар байрт, эмэгтэйчүүдийн ангилалдаа зургадугаар байрт шалгарч нийлбэр дүнгээр гуравдугаар байрт шалгарчээ. Төрлүүдээр ангилбал эрэгтэй төрөлд хүрэл медалийг “Соёмбо” багийн тамирчин Л.Насанжаргал, мөнгөн медалийг “Эрхэс” багийн тамирчин Д.Өлзийбат, алтан медалийг “Бизнес хөгжил” багийн тамирчин Б.Мөчрөө нар авсан байна. Харин эмэгтэйчүүдийн ангилалд хүрэл медалийг “Аврагч” багийн тамирчин О.Сарангоо, мөнгөн медалийг “Политехникийн коллеж” багийн тамирчин Х.Анхсүрэн, алтан медалийг “Бизнес хөгжил” багийн тамирчин М.Мичидмаа нар хүртжээ.

Усан сэлэлтийн 35 насны ангилалд Х.Отгонжаргал тэргүүлээ



Усан сэлэлтийн төрөлд 100 гаруй тамирчид оролцож шилдгүүдээ тодруулсан байна. Тус тэмцээний эмэгтэйчүүдийн +35 насны ангилалд хүрэл медалийг “Шонхор” багийн тамирчин Б.Энхтуул, мөнгөн медалийг “Шар арслан” багийн тамирчин



Л.Одонтуяа, алтан медалийг “Бизнес хөгжил” багийн тамирчин Х.Отгонжаргал, эрэгтэйчүүдийн +35 насны ангилалд хүрэл медалийг “Талын шонхор” багийн тамирчин Д.Мөнх-Эрдэнэ, мөнгөн медалийг “Шингэн алт” багийн тамирчин Ж.Насанбат, алтан медалийг “Шонхор” багийн тамирчин Э.Түмэнбаяр нар тус тус авчээ. Мөн усан сэлэлтийн эмэгтэйчүүдийн -35 насны ангилалд хүрэл медалийг “Ганзам” багийн тамирчин Болормаа, мөнгөн медалийг “Бизнес хөгжил” багийн тамирчин Б.Уянга, алтан медалийг “Ганзам” багийн тамирчин Б.Энхчимэг хүртсэн бол эрэгтэйчүүдийн -35 насны ангилалд хүрэл медалийг “Политехник коллеж” багийн тамирчин П.Мөнхцож, мөнгөн медалийг “Бизнес хөгжил” багийн тамирчин Б.Мөнгөншагай, алтан медалийг “Шар арслан” багийн тамирчин Б.Батмөнх хүртсэн байна. Харин Усан сэлэлтийн “Холмог буухиа” төрөлд хүрэл медалийг Э.Түмэнбаяр ахлагчтай “Шонхор” багийн баг тамирчид, мөнгөн медалийг Э.Мөнхчулуун ахлагчтай “Аврагч” багийн баг тамирчид, алтан медалийг А.Золбаяр ахлагчтай “Бизнес хөгжил” багийн баг тамирчид хүртсэн байна.

Гар бөмбөгийн төрөлд 39 багийн 300 тамирчин өрсөлдсөн гэв



“Спортын бага наадам”-ын нэг дэх долоо хоног ийнхүү амжилттай өндөрлөж, шилдгүүдээ тодруулсан юм. Харин хоёр дахь долоо хоногт Хөлбөмбөг, Гарбөмбөг, Үндэсний бөх, Теннис, Олс таталтын тэмцээн зохион байгуулагдсан. Тухайлбал, гар бөмбөгийн төрөлд эрэгтэй 19, эмэгтэй 20 багийн 300 гаруй баг тамирчид долоо хоногийн турш хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлджээ. Тэмцээний дүнгээр эмэгтэйчүүдийн ангилалд Хүрэл медалийг О.Одцаралт ахлагчтай “Ганзам” баг, мөнгөн медалийг А.Дэлгэрмаа ахлагчтай “Шонхор” баг, алтан медалийг О.Пүрэвсүрэн ахлагчтай “Банкууд” багийн тамирчид хүртсэн байна. Эрэгтэйчүүдийн ангилалд гуравдугаар байрт Б.Азидьяа ахлагчтай “Сансар” баг, хоёрдугаар байрт Э.Оюунболд ахлагчтай “Эрчим” баг, нэгдүгээр байрт Б.Мөнхзаяа ахлагчтай “Шивээ-Овоо” ХК-ийн баг тамирчид шалгарчээ. Мөн “Шилдэг хамгаалагч”-аар эмэгтэйчүүдийн ангилалд “Шонхор” багийн тамирчин А.Дэлгэрмаа, эрэгтэйчүүдийн ангилалд “Шивээ-Овоо” ХК-ийн багийн тамирчин О.Төгөлдөр, “Шилдэг довтлогч”-оор эмэгтэйчүүдээс “Банкууд” багийн тамирчин О.Пүрэвсүрэн, эрэгтэйчүүдээс “Эрчим” багийн тамирчин Э.Оюунболд нар шалгарсан байна.



Ширээний теннисийн ганцаарчилсан төрөлд Л.Энхмөнх алтан медаль авав



“Спортын бага наадам”-ын ширээний теннисийн төрөлд 20 багийн 120 тамирчид оролцсон байна. Ширээний теннисийн тэмцээн ганцаарчилсан болон холимог хос төрөлд зохион байгуулагдаж, шилдгүүдээ шалгаруулсан байна. Тодруулбал, эмэгтэйчүүдийн ганцаарчилсан төрлийн нэгдүгээр байрт “Политехник коллеж” багийн тамирчин Л.Энхмөнх, хоёрдугаар байрт “Илч” багийн тамирчин Г.Эрдэнэцэцэг, гуравдугаар байрт “Эрчим” багийн тамирчин П.Мөнгөнцэцэг нар шалгарчээ. Харин эрэгтэйчүүдийн ганцаарчилсан төрлийн алтан медалийг “Соёмбо” багийн тамирчин Г.Ганбаатар, мөнгөн медалийг “Шивээ-Овоо” ХК-ийн багийн тамирчин Л.Энхбаяр, хүрэл медалийг “Шивээговь” багийн тамирчин Э.Төмөрболд нар хүртсэн байна. “Холмог хос” төрлийн нэгдүгээр байрт “Политехникийн коллеж”-ийн багийн С.Ганзориг, Л.Энхмөнх, хоёрдугаар байрт “Эрчим” багийн Р.Чинболд, П.Мөнгөнцэцэг, гуравдугаар байрт “Шивээ-Овоо” ХК-ийн багийн Л.Энхбаяр, Г.Ялалт нар шалгарч, шилдгээр тодорлоо.

Үндэсний бөхтэй “Спортын бага наадам”



“Спортын бага наадам”-ын бас нэгэн онцлог нь үндэсний бөхийн тэмцээн байлаа. Монголын уламжлал, үндэсний спортыг хөгжүүлэх зорилгоор үндэсний бөхийн барилдааны төрлийг бага наадмын төрөлд оруулсан гэнэ. Монгол бөхийн барилдаанд нийт 20 багийн 40 бөх оролцсон байна. Ингээд үндэсний бөхийн барилдааны мэдээллийг хүргэе. Нийт 40 гаруй бөх оролцсон тус тэмцээнд “Шивээ-Овоо” ХК-ийн багийн тамирчин Б.Түвшинбаатар 17 даван түүрүүлж, “Аврагч” багийн тамирчин З.Оч-Эрдэнэ үзүүрлээ. Улмаар “Эрхэс” багийн тамирчин Э.Түвшинзаяа, “Ганзам” багийн тамирчин Э.Идэрсайхан, “Талын шонхор” багийн тамирчин Г.Эрхэмбаатар, “Сансар” багийн тамирчин Э.Азидьяа нар шөвгөрчээ. Хөлбөмбөгийн тэмцээнд нийт 20 багийн 200 гаруй тамирчид хурд хүчээ сорин өрсөлдсөн байна. Тус тэмцээний Нэгдүгээр байрт Ж.Ням ахлагчтай “Илч” баг, хоёрдугаар байрт н.Алтансүр ахлагчтай “Шивээ-Овоо” ХК-ийн баг, гуравдугаар байрт Ц.Даваадалай ахлагчтай “Сансар” баг оржээ. Түүнчлэн “Шилдэг хамгаалагч”-аар “Шивээ-Овоо” ХК-ийн багийн тамирчин М.Пүрэвсүх, “Шилдэг довтлогч”-оор “Шивээ-Овоо” ХК-ийн багийн тамирчин Ч.Батцолмон нар шалгарсан байна.

Олс таталтын тэмцээн амжилттай боллоо




Говьсүмбэр аймгийн Засаг даргын нэрэмжит “Спортын бага наадам”-ийн олс таталтын төрөлд 18 багийн 180 тамирчид өрсөлдсөн байна. Тус тэмцээний нэгдүгээр байрт А.Золбаяр ахлагчтай “Бизнес хөгжил” баг, хоёрдугаар байрт З.Оч-Эрдэнэ ахлагчтай “Аврагч” баг, гуравдугаар байрт И.Жамьянхорол ахлагчтай “Шивээ-Овоо” ХК-ийн баг тамирчид шалгарчээ. Ийнхүү тус наадам олс таталтын тэмцээнээр өндөрлөсөн юм. Мөн “Спортын бага наадам”-ын төгсөлд тэмцээнд оролцсон нийт багуудыг нэгдсэн дүнгээр байр эзэлүүлсэн байна. Тодруулбал, нэгдүгээр байрт, Б.Төгсбаяр даргатай УБТЗ-ын Чойр өртөө, Барилга ашиглалт үйлчилгээний хоёрдугаар ангийн харьяа Чойр дахь хэсэг, Чойр солилцох тасаг, Сансар цэцэрлэгийн хамтарсан “Ганзам” багийн хамт олон шалгарч, аваргын цомын эзэд болжээ. Харин хоёрдугаар байрт А.Азбаяр даргатай БЗӨБЦСүлжээ ТӨХК-ийн Говьсүмбэр салбар, БЗӨБЦСүлжээ ТӨХК-ийн Чойр хэсгийн хамтарсан “Эрчим” баг, гуравдугаар байрт Ш.Отгонжаргал захиралтай Политехникийн коллежийн багууд тус тус шалгарчээ.

ГОВЬСҮМБЭРИЙН МЭДЭЭ

ДУУЛГАХ СОНИН

ХҮҮХЭД, БАГАЧУУДЫН НӨХӨР



Н.ЗАЯА

Говьсүмбэр аймгийн Татварын хэлтэсээ санаачлан зохиолч Р.Батжаргал шүлгийг бичиж, зураач Б.Мөнх-Өлзий зургийг нь зурж "Тоодой хүү" нэртэй ном бүтээсэн байна. Энэхүү ном нь Сургуулийн өмнөх болон ЕБС-ийн сурагчдад татварын боловсрол олгоход чиглэгдсэн. Тус номын нээлтийн үйл ажиллагааг Татвар төлөгчдийн өдрүүдийг тохиолдуулан зохион байгуулсан нь "Нээлттэй өдөрлөг"-ийн үеэр болжээ. Номын нээлтэд Сүлбэр сумын хоёр, тав болон "Сансар"



цэцэрлэгийн багачууд болон хоёрдугаар сургуулийн IV ангийн сурагчид оролцжээ. Нээлтэд хүрэлцэн ирсэн хүүхэд багачуудад номынхоо дээжээс бэлэглэсэн байна. Энэ талаар Говьсүмбэр аймгийн Татварын газрын дарга П.Энх-Оюунтай цөөн хорол ярилцлаа.

-Жил бүрийн тавдугаар сарын хоёр дахь долоо хоногт "Татвар төлөгчдийн өдөр"-ийг улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлдэг. Танай аймгийн хувьд "Татвар төлөгчдийн өдөр"-ийг хэрхэн тэмдэглэв. Бусад аймгуудаас ялгарах ямар ажил зохион байгуулсан бэ?

-Засгийн газраас жил бүрийн тавдугаар сарын хоёр дахь долоо хоногийг "Монголын татвар төлөгчдийн өдөр" болгон тэмдэглэж 18 дахь жилтэйгээ золгож байна. Энэ хүрээнд Татварын ерөнхий газраас нэгдсэн чиглэл, удирдамжийн дагуу хийгддэг ажлууд нэлээдгүй бий. Тухайлбал, ЕБС-ийн

сурагчдын дунд гар зураг, зохион бичлэгийн уралдаан зарладаг. Мөн уран бүтээлчдийн дунд ч гэсэн уралдаан, тэмцээн зохион байгуулдаг. Говьсүмбэр аймгийн Татварын хэлтсийн хувьд дээрээс ирсэн чиглэлээс гадна онцлог хэд хэдэн ажлыг орон нутагтаа зохион байгууллаа. Ирээдүйн татвар төлөгчдийн татварын боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор "Тоодой хүү" комикс номыг бүтээлээ. Энэхүү номын зохиолчоор МЗЭ-ийн яруу найрагч Р.Батжаргал, зураачаар Б.Мөнх-Өлзий нар ажилласан. Энэхүү ном маань орон нутгийн төвшинд анх удаа хэвлэгдэж буйгаараа онцлогтой. Түүнчлэн татвар төлөгчдөд чиглэсэн дууны шүлгийн уралдаан зохион байгууллаа. Уг уралдаанд Дорноговь, Говьсүмбэр аймгийн зургаан уран бүтээлч бүтээлээ ирүүлсэн. Шалгарсан нэг шүлгийг дуу болгохоор Дуу бүжгийн Боржигин чуулгатай хамтарч ажиллахаар төлөвлөдөг байна.

-2017 онд улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх

орлогын гүйцэтгэлийн төлөвлөгөөнийхөө талаар мэдээлэл өгөхгүй юу?

-2017 оны эхний дөрвөн сарын байдлаар татварын хэлтэс маань улс, орон нутгийн төсөвт нийт 2.452.6 сая төгрөг төвлөрүүлжээс 2.462.8 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 100.4 хувиар биелүүлжээ.

"Тоодой хүү ном орон нутгийн хэмжээнд анх удаа хэвлэгдсэн гэлээ. Номын агуулгын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?"

-Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдад зориулан татвар гэж юу болох, татвар юунд зарцуулагддаг болох, татвар төлөхийн ач тус юу вэ гэдгийг таниулах үүднээс "Тоодой хүү" нэртэй комикс номыг бид бүтээсэн юм. Ном маань шүлгээр дамжуулж ирээдүйн татвар төлөгчдөд татварын боловсрол олгоход чиглэснээрээ онцлог юм. Ном маань 500 хувь хэвлэгдсэн. Бид дахин хэвлэж хүүхдүүдэд тараахаар төлөвлөдөг байна.

МЗЭ-ийн гишүүн, яруу найрагч Баатарын Энхтөр

Татварын хишиг

Улс дэвжихийн эрдэнэсийн хуримтлал Олноороо бүтээхийн хишиг өглөг Өрнүүн хөгжлийн төлөө сэтгэлтэн Үйлс нь дээшээ Татвар төлөгч Та Татварын хишиг түмнийхээ төлөө билээ Татвар төлөгч тандаа баярлалаа Өтгөстөө хүртээх сэтгэлийн хандив Үрсдээ босгох ирээдүйн алтан сан Залуустаа өргөх итгэлийн урам Сайхан амьдрах хөгжлийн түлхүүр Татварын хишиг түмнийхээ төлөө билээ Татвар төлөгч тандаа баярлалаа Төр оршихуйн түүхэн уламжлал Түмэнтэйгээ туулах нийгмийн зүтгэл Ажлаараа бахархах хүмүүний алдар Ардынхаа төлөө Татвар төлөгч Та Татварын хишиг түмнийхээ төлөө билээ Татвар төлөгч тандаа баярлалаа

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ



БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Говьсүмбэр аймагт ажиллав

Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, ОБЕГ-ын байнгын ажиллагаатай зөвлөлийн нарийн бичгийн дарга З.Баттулга, Нийслэлийн МХГ-ын барилгын техникийн хяналтын Улсын ахлах байцаагч Т.Энхтүвшин болон бусад албаны хүмүүс Говьсүмбэр аймагт ажиллажээ. Ажлын хүрээнд аймгийн төвийн нийтийн орон сууц, олон нийтийн зориулалтын барилга байгууламжийн чанар, газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлын урьдчилсан үзлэгтэй танилцсан байна. Мөн Онцгой байдлын газар, Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх, шуурхай урирдлага, зохицуулалтаар хангах төвтэй танилцаж аймгийн газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай дэд зөвлөлийг хуралдуулжээ. Түүнчлэн Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн аймгийн урирдлагуудын хүсэлтийн дагуу Ус-Ду ААТОНӨҮГ-ийн уурын

зуухтай танилцсан аж. Тус уурын зуух нь 11 жил ашиглагдаж байгаа бөгөөд ашиглалтын хугацаа дууссан байна. Үүний улмаас үргэлж эвдрэл гэмтэл гарч, хэвийн үйл ажиллагаа алдагдах болжээ. Үүнтэй холбогдуулан МХГ-аас ашиглах боломжгүй гэсэн дүгнэлтийг сүүлийн хоёр жил гаргаж буй талаар аймгийн удирдлагууд Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэнд уламжилсан аж. Мөн "Зуухыг бүхэлд нь шинэчлэх хөрөнгө мөнгө дутагдалтай байсан учир урсгал болон их засварын ажлуудыг өөрийн болон орон нутгийн хөгжил сангийн хөрөнгөөр хийж байсан. Гэхдээ элэгдэж муудсан тоног төхөөрөмж ашиглалтын шаардлага хангахгүй байгаа" хэмээн тайлбарласан юм. Харин энэ үеэр Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн Яам, Засгийн газрын төвшинд танилцуулж өөрийн зүгээс туслаж дэмжихээ илэрхийлжээ.

Мэдээлэл технологийн даамлын сургалт болжээ

Сонгуулийн ерөнхий хорооноос батлагдсан хуваарийн дагуу аймаг, сумдын хэсгийн хороонд сонгуулийн санал тоолох төхөөрөмжийг хариуцан ажиллах орон даяар зохион байгуулж байгаа билээ. Энэхүү сургалтыг Говьсүмбэр аймагт тавдугаар сарын 19-нд амжилттай зохион байгуулсан байна. Сургалтыг Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн программ хангамжийн инженер

П.Алтанчимэг, С.Отгонсүрэн эрхлэн явуулсан аж. Сургалтын үеэр сонгуулийн автоматжуулсан систем, түүний эрх зүйн орчин, санал тоолох төхөөрөмж, зурган файл хуулах, өгөгдөл дамжуулах туршилтын өдрийн заавар, санал тоолох төхөөрөмж дээр ажиллах дадлага ажил, гарч болох зарим асуудлыг шийдвэрлэх талаар мэдээлэл өгчээ. Мөн сургалтын төгсгөлд нийт оролцогчдоос шалгалт авч үнэмлэх, гэрчилгээ олгосон аж.

САЙН МЭДЭЭ



"ШИЛДЭГ ГЭР БҮЛ"-ийг шалгаруулжээ



НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1993 оны есдүгээр сарын 20-ны хэлэлцээрээр 1994 оноос эхлэн жил бүрийн тавдугаар сарын 15-ны өдрийг "Гэр бүлийн өдөр" болгон тэмдэглэх тухай тогтоол гаргасан байдаг. Харин манай улс уг өдрийг 12 дахь удаагаа орон даяар тэмдэглэн өнгөрүүлж байгаа билээ. Тэгвэл "Дэлхийн гэр бүлийн өдөр"-ийг Говьсүмбэр аймаг тэмдэглэн өнгөрүүлсэн байна. Тус өдрийг тохиолдуулан Говьсүмбэр аймгийн ЗДТГ, ГБХЗХГазар, дуу бүжгийн "Боржигин" чуулга, Дэлхийн зөн Бор-Өндөр ОНХХ-гэй хамтран "Хүүхэд гэр бүлдээ аз жаргалтай" өдөрлөгийг зохион байгуулжээ. Өдөрлөгийн үеэр "Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүчирхийлэлээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ", "Өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэнд тулгамдаж буй асуудал", "Гэр бүлийн үнэ цэнэ" зэрэг сэдвээр лекц уншсан гэнэ. Мөн урилгаар ОУУБИСургуулийн доктор профессор Б.Оюун-Эрдэнэ "Хүүхэд гэр бүлдээ аз жаргалтай" сэдвээр лекц уншсан байна. Энэ үеэр шилдэг есөн гэр бүлийг шалгаруулсан аж. "Спортлог гэр бүл"-ээр Н.Идэржавхлан, Д.Солонготуяа, "Авьяаслаг гэр бүл"-ээр Д.Нацагдорж, С.Дулмаахүү, "Хүмүүнлэг гэр бүл"-ээр Я.Дамдиндоо, Ч.Болормаа нар шалгарчээ. Харин "Оюулаг гэр бүл"-ээр Д.Амарсайхан, Д.Зандарьяа, "Хөдөлмөрч гэр бүл"-ээр Д.Жамсран, Ө.Дэлгэр, "Өв соёлоо дээдлэгч гэр бүл"-ээр Г.Ганхуяг, "Үлгэр жишээч гэр бүл"-ээр Д.Цогбадрах, М.Сэртэв, "Өнөр гэр бүл"-ээр Д.Жаалхүү, "Бүтээлч гэр бүл"-ээр Ц.Бөхбат, Р.Баасансүрэн нарын гэр бүлийг шалгаруулж өргөмжлөл үнэ бүхий зүйлээр шагнажээ.

"ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР" САРЫН АЯН ЭХЭЛЛЭЭ



Н.ЗАЯА

"Зохистой хөдөлмөр" аяны нээлт өнгөрсөн даваа гарагт Говьсүмбэр аймагт боллоо. Тус аяны нээлтэд Говьсүмбэр аймгийн Засаг даргын орлогч Ш.Билэгтүмбэрэл, Эрүүл мэнд, даатгалын хэлтсийн дарга Б.Аюушжав, Хөдөлмөрч халамжийн үйлчилгээний газрын дэд дарга Т.Баясгалан, МХГ-ын дарга Б.Ганбаяр болон төрийн байгууллагын ажилчид оролцлоо. Тус аяныг нээж, МХГ-ын дарга Б.Ганбаяр "Байгууллагын үйл ажиллагаа болон хууль тогтоомжийг сурталчлах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор сарын аяныг

хяналтын чиглэл бүрээр сарын аяныг зохион байгуулж байгаа билээ. Тухайлбал, өнгөрсөн гуравдугаар сард "Эрүүл аюулгүй хүнс", дөрөвдүгээр сард "Дэд бүтцийн хяналтад таны оролцоо" сэдэвт сарын аянуудыг тус тус зохион байгуулаад байна. Говьсүмбэр аймгийн хэмжээнд ажлын байрны эрсдэлийн төвшин ихтэй уул уурхай, эрчим хүч, газрын тос, барилгын салбар болон үйлдвэрлэлийн аюултай хортой хүчин зүйлс бүхий 30 гаруй аж ахуй нэгжид 1300 гаруй хүн ажил хөдөлмөр эрхэлж байна. Манай аймагт сүүлийн таван жилд 25 удаагийн үйлдвэрлэлийн осолд 30 хүн өртсөнөөс хоёр хүн амиа алдаж, хоёр хүн хөгжлийн бэрхшээлтэй болсон

гэсэн харамсалтай тоо баримт байна. Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, үйлдвэрлэлийн осолгүй ажиллах нь дан ганц хууль хяналтын байгууллага, ажил олгогч, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажилтнаас бус ажил хөдөлмөр эрхэлж буй ажилтнаас ихээхэн хамаарч байгааг дэлхий нийт зөвшөөрсөн. Иймээс ажилтан бүр аюулгүй байдлаа өөрсдөө хангаж, өөрийгөө болон хамт ажиллагсдыгаа эрсдэлд оруулахгүй байх, аюулгүй байдлаа хангуулахаар ажил олгогчид шаардлага тавих нь ажилтан таны хуулиар хүлээсэн эрх, үүрэг билээ. Мэргэжлийн хяналтын байгууллагаас хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, олон нийтэд сурталчлах аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор олон төрлийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлдгийн нэг нь сарын аян юм" гэв. Тус аяны хүрээнд "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал", "Үйлдвэрлэлийн осол хурц хордлогыг судлан бүртгэх арга" нэгдсэн сургалт, мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, нийгмийн хариуцлага, бүтээмжийг нэмэгдүүлэх, иргэдийн цэвэр орчинд ая тухтай ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулах, шинээр үйл ажиллагаа эрхэлж буй ААНБ-уудад зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх зэрэг олон үйл ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөжээ. Аян зургадугаар сарын 15-ныг хүртэл үргэлжлэх юм байна.